

“ХЭРЭГЛЭЭНИЙ ХЭЛ ШИНЖЛЭЛ” сэтгүүлийн 2024 оны дугаарт өгүүлэл хүлээн авна.



ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбараас эрхлэн гаргадаг “Хэрэглээний хэл шинжлэл” сэтгүүл нь жилд 1 удаа хэвлэгддэг, олон улсын ISSN: 2524-0951 дугаартай эрдэм шинжилгээний сэтгүүл юм. Агуулгын хувьд нэр томъёо судлалын онол, арга зүй, хэрэглээ болон хэрэглээний хэл шинжлэлийн бусад чиглэлийн өргөн хүрээг хамардгаараа онцлогтой бөгөөд эрдэм шинжилгээний өгүүлэл, тойм өгүүлэл, сурталчилгааны өгүүлэл, эрдэм шинжилгээний орчуулга, шүүмж, мэдээ мэдээлэл гэсэн хэсгээс бүрдэнэ. “Хэрэглээний хэл шинжлэл” сэтгүүлд ирүүлсэн бүх бүтээлд хөндлөнгийн давхар хянан магадалгаа хийнэ. Энэ жилийн дугаараас эхлэн цаасан хэлбэрээр хэвлэгдэхээс гадна <https://www.mongoliajol.info/>-д бүртгүүлэн цахим хэлбэрээр нийтлэгдэх тул гадаад, дотоодод эшлэгдэх боломж ихэснэ. Эрдэмтэн, судлаач та бүхнийг “Хэрэглээний хэл шинжлэл” сэтгүүлийн 2024 оны дугаарт эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэхийг урьж байна.

“Хэрэглээний хэл шинжлэл” сэтгүүлийн IX ботгийн өгүүлийг 2024 оны 4 сарын 15 хүртэл munkhtsetsegn@mas.ac.mn цахим хаягаар хүлээн авна.

Өгүүлэл хүлээн авах: 2024.01.02 – 2024.04.15

Редакцын зөвлөл хянах: 2024.04.16 - 2024.05.15

Сэтгүүлд тэнцсэн эсэхийг мэдэгдэх: 2024.05.31

Өгүүлийг засах: 2024.06.01 - 2024.06.30

Сэтгүүлийг хэвлэлд бэлтгэх, хэвлүүлэх: 2024.07.01 - 2024.08.01

Өгүүлд тавигдах шаардлага

- Эрдэм шинжилгээ, онол арга зүйн өндөр түвшинд бичигдсэн байх;
- Судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнд түшиглэсэн эсвэл хуучин эх хэрэглэгдэхүүнийг шинэлэг байдлаар нэгтгэн авч үзсэн байх;
- Зохиогч өөрийн хийсэн судалгааны ажлын үр дүнд үндэслэн бичсэн, өөр хэвлэлд хэвлэн нийтлээгүй, шинэлэг байх шаардлагатай.

Өгүүлийн бүтэц:

- БҮТЭЭЛИЙН НЭР (Бүтээлийн англи нэрийн хамт)
- ЗОХИОГЧИЙН НЭР
- ХУРААНГУЙ (100-200 үгтэй, англи, монгол хэлээр бичсэн байх)
- ТҮЛХҮҮР ҮГ (англи, монгол хэлээр бичсэн байх)
- 1.УДИРТГАЛ
- 2.СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ
- 3.СУДАЛГААНЫ ХЭСЭГ (Гарчгийг бичсэн байх)
- 4.СУДАЛГААНЫ ҮР ДҮН (ХЭЛЭЛЦҮҮЛЭГ)
- 5.ДҮГНЭЛТ

- НОМ ЗҮЙ гэсэн үндсэн хэсгүүдтэй байна.
- ТАЛАРХАЛ (Хэрэв шаардлагатай бол)
- ХАВСРАЛТ (Хэрэв шаардлагатай бол)

Өгүүллийн хэлбэр:

Цаасны хэмжээ	A4 , хуудасны тоо 10-аас доошгүй (5000 үгээс хэтрэхгүй)
Цаасны хүрээ	Бүх талаас 25мм (дээд, доод, баруун, зүүн)
Фонт	Times New Roman, үсгийн хэмжээ 11-pt
Мөр хоорондын зай	1.15 (space)
Догол мөр	5 нэгж
Гарчиг	Гарчиг болон судлаачийн мэдээллийг эхний хуудсанд байрлуулна. Өгүүллийн нэрийг том үсгээр, тод хараар бичиж, дор нь баруун талд зохиогчийн овог нэр, улс, хот, ажил (сургууль, байгууллага)-ын нэрийг бичих
Үндсэн болон дэд бүлэг гарчиг	Үндсэн бүлгүүдийн нэрийг хуудасны төвд том үсгээр бичнэ. Дэд бүлгийн гарчиг нь хуудасны зүүн талд байрлах бөгөөд том эсвэл жижиг үсгээр бичиж болно. Гарчгуудыг 1, 1.1, 1.1.1 гэх мэтээр дугаарлана.
Хүснэгт, зураг	Хүснэгт болон зураг нь нэгдмэл дараалсан дугаартай, агуулгаа тодорхойлсон нэртэй байх ёстой. Хүснэгтийн нэрийг дээр нь, зургийн нэрийг доор нь голлуулан бичнэ. Тайлбар болон эх сурвалжийн талаарх нэмэлт мэдээллийг бичнэ.
Зүүлт тайлбар (footnote)	Үгийн тайлбар, засвар, залруулга, нэмж судлах материалуудын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгөх зэрэг тохиолдолд хэрэглэж болно.
Товчлол	Товчилсон үгийн жагсаалтыг цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаан товчлолыг эхэнд бичиж ард нь тайллыг бичнэ.

Жич: Өгүүллийн бүтцийн загварт 6th edition of the American Psychological Association (APA)-г баримтална.

Эшлэлд дараах загварыг баримтална.

- Аливаа эх сурвалжаас ямар ч хэмжээний мэдээллийг шууд эш татсан, хураангуйлан бичсэн, өөрийн үгээр найруулан бичсэн зэрэг бүх тохиолдолд тухайн эх сурвалжийг бичвэр дотор эшлэх ба ном зүйн жагсаалтад оруулна.
- Wikipedia-аас эшлэл авахгүй.

1.Бичвэр дотор утга санаагаар эшлэхдээ: зохиогчийн нэрийн ард хаалтад тухайн бүтээлийн оныг бичнэ. Жишээ нь: Оросын хэл шинжлэлч Н.В.Васильева (1999) хэл шинжлэлийн нэр томьёог “тогтолцооны тогтолцоо” хэмээн үзсэн байдаг.

2.Бичвэр дотор шууд эшлэхдээ:

Хувилбар 1: Хэрэв зохиогчийг өгүүлбэрийн эхэнд дурдан түүний бүтээлээс шууд эшилбэл, эшлэл (40-өөс доош үгтэй)-ийг хашилтад бичиж ард нь хаалтад он, хуудсыг бичнэ. Жишээ нь: Нэр томьёо судлаач Ч. Догсүрэн “Нэр томьёог гадаад хэлнээс үгчлэн буюу хуулбарлан буулгана гэдэг бол үгийн хэлбэрийг нь биш дотоод утгыг нь зээлдэж байгаа хэрэг юм” (1988:22) гэжээ.

Хувилбар 2: Хэрэв шууд эшлэл нь 40-өөс дээш үгтэй бол бичвэрийг хашилтад хийхгүйгээр догол мөрөөр авч налуу үсгээр бичиж, ард нь (Зохиогч, он: хуудас) гэж эх сурвалжийг бичнэ. Жишээ нь:

Нэр томъёог гадаад хэлнээс үгчлэн буюу хуулбарлан буулгана гэдэг бол үгийн хэлбэрийг нь биш дотоод утгыг нь зээлдэж байгаа хэрэг юм. Нэр томъёог гадаад хэлнээс үгчлэн буюу хуулбарлан буулгана гэдэг бол үгийн хэлбэрийг нь биш дотоод утгыг нь зээлдэж байгаа хэрэг юм. Иймд үгчлэн орчуулах аргаар нэр томъёо бүтээхдээ зөвхөн үгийн өнгийг голлох биш, уг үгээр илэрч байгаа утгыг давхар маш сайн бодолцох хэрэгтэй. Уг утга нь эс бууваас уг нь хэчнээн зөв буюгаад ч хэрэггүй. Нэр томъёочид зарим үед уг утгын энэ холбоог эс анзаарснаас гоомойдсон газар цөөнгүй дайралдаж байна (Догсүрэн, 1988: 22)

3. Олон зохиогчтой бүтээлээс эш татах:

Хувилбар 1: 2 зохиогчтой бүтээлээс эшилсэн бол эшлэх тохиолдол бүрд 2 зохиогчийн нэрийн аль алиныг дурдана. Жишээ: Нэр томъёо судлаач Дашдаваа, Равдан нар (1988) энэ тухайд...

Хувилбар 2: 3-5 зохиогчтой бүтээлээс эш татвал хамгийн эхний эшлэлийн тайлбарт бүх зохиогчийн нэрийг бичээд дараа нь тэр бүтээлээс дахин эш татсан тохиолдолд зөвхөн эхний зохиогчийн нэрийг дурдаад бусад зохиогчийн нэрийг бичилгүй “ба бусад,” (“и др.,” “et al.,”) гэж товчилно. Жишээ нь:

Хувилбар 3: Ижил зохиогчтой бүтээлүүдийг Thompson & Heck (2002a, b) эсвэл (Thompson & Heck, 2002a, b) хэлбэрээр эшлэх ба нэг доор олон бүтээлийг зэрэг эшлэх тохиолдолд (Smith, 1985; Johnson, 1990; Beynon, 2001) г.м-ээр он дарааллаар бичнэ.

4. Өөр хэлээр хэвлэгдсэн эх сурвалжаас эшлэл авахдаа:

Үндсэн бичвэрт агуулгыг монгол хэлээр эшилж, харин зохиогчийн нэрийг тухайн хэлээр нь бичнэ. Жишээ нь: Дүрслэлт адилтгал гэж нэг ухагдахууны дотоод бүтэц буюу шинжийг нөгөө бүтцэд шилжүүлэхийг хэлдэг (Lakoff, 1992: 418) гэх мэт.

Ном зүйд дараах шаардлагыг баримтална. Үүнд:

- Ном зүйг footnote-өөр хийхгүй.
- Эх сурвалжуудыг дугаарлахгүй.
- Ном зүй дэх эх сурвалжуудыг жагсаахдаа цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ. Хэрэв гадаад эх сурвалж ашигласан бол ном зүйг А.Монгол хэлээр, Б.Англи ба бусад хэлээр гэж ангилан бичнэ.
- Эшлэл аваагүй зохиогчийн нэрийг ном зүйд оруулахгүй. Өөрөөр хэлбэл, эшлэл, ном зүй тохирч байх ёстой.

Ном:

- 1 зохиогчтой бол:
Бадамдорж, Д. (2006). *Монгол хэлний үгийн сангийн утга зүй*. Улаанбаатар: Адмон ХХК. [Badamdorj, D. *Mongol helnii ügiin sangiin utga züi* [Mongolian Lexical Semantics]. Ulaanbaatar: Admon LLC. 2006.]
- 2 зохиогчтой бол:
Мөнх-Амгалан, Ю., Кан Шин. (2014). *Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Mönh-Amgalan, Yu., Kang Shin. *Orchin tsagyn mongol helnii büteever sudlal* [The Morphology of Modern Mongolian]. Ulaanbaatar: Soyombo printing. 2014.]
- 3 ба түүнээс дээш зохиогчтой бол:
Гэрэлмаа, Г., Шинэбаяр, О., Мөнхцэцэг, Н., Бат-Эрдэнэ, С. (2014). *Монгол нэр томъёо судлалын товчоон*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Gerelmaa, G., Shinebayar, O.,

Münkhtsetseg, N., Bat-Erdene, S. *Mongol ner tomyo sudlalyn товчоон* [Historical Outline of Mongolian Terminology Studies]. Ulaanbaatar: Soyombo printing. 2014.]

- Эмхтгэгч бүхий эх сурвалжийг ном зүйд оруулахдаа эмхтгэгчийн овог, нэрийг дээрх зарчмаар бичих ба ард нь таслалаар зааглан (эмх.) (ред.) (ed.) гэсэн үгийг нэмж оруулна. Жишээ нь: Мөнхцэцэг, Н., Шинэбаяр, О. (эмх.), (2014). *Монгол нэр томъёо судлал-90*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Munkhtsetseg, N., Shinebayar, O. *Mongol ner tomyo sudlal-90* [Mongolian Terminology Studies-90]. Ulaanbaatar: Soyombo printing. 2014.]

Өгүүлэл:

- 1 зохиогчтой бол: Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр, Сэтгүүлийн гаралтын дугаар* (тухайн оны дугаар), Хуудасны дугаар. Жишээ нь: Адьаа, О. (2009). Гадаад үг, нэр томъёог монгол хэлнээ хэрэглэх тухайд. *Нэр томъёо судлал, 11*: 62-70. [Adiya, O. On the Use of Foreign Words and Terms in Mongolian. *Ner tomyo sudlal, 2009, 11*: 62-70.]
- 2 ба түүнээс дээш зохиогчтой бол: Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор., Хоёр дахь зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр, Сэтгүүлийн гаралтын дугаар* (тухайн оны дугаар), Хуудасны дугаар. Жишээ нь: Батмөнх, С., Эрдэв, Б. (2004). Техник технологийн нэр томъёог сурах бичигт хэрэглэж буй байдал, түүнийг жигдлэх асуудалд. *Нэр томъёо судлал, 6*: 83-88. [Batmunkh, S., Erdev, B. The Current State of Technical and Technological Term Usages in Textbooks and Its Harmonization. *Ner tomyo sudlal, 2004, 11*: 83-88]
- Цахим сүлжээнээс авсан эх сурвалжийг ном зүйд оруулахдаа “Available at” эсвэл “Retrieved from” гэсэн үг бичнэ. “Available at” гэдэг нь судлаач тухайн эх сурвалжийг төлбөртэй авч ашигласан гэсэн санааг илтгэнэ. Энэ тохиолдолд эх сурвалжийн цахим хаягийг тодорхой тусгах шаардлагатай байдаг. Жишээ нь: Humbley, J. (2009). Accounting for term formation. *Terminology Science and Research* 20. Available at <http://lipas.uwasa.fi/hut/svenska/iitf/tsr2005/vol20/>. Accessed 15 June 2010.
- “Retrieved” гэдэг нь судлаач интернэтээс авсан эх сурвалжийг үнэ төлбөргүй авч ашигласан гэсэн санааг илтгэнэ. Жишээ нь: Lai, Gorman Yuan and Liberman (2008) Perception of Disfluency Language Differences and Listener Bias. *Interspeech* 18. pp. 2345-2348. <http://dx.doi.org/10.1.1.165.6866>. Retrieved from www.ling.upenn.edu/~kgorman/papers/laietal2007.pdf

Жич: Зохиогч та бүхэн өгүүллийн стандарт шаардлага болон зохиогчийн эрх, оюуны өмчийн тухай хуулийн заалтыг чанд мөрдөн гүйцэтгэнэ үү.

Холбоо барих: Н.Мөнхцэцэг 91719091

ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар